

**БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГЫН СУДАЛГААНЫ ЧИГ ХАНДЛАГА: 2002-2017***Г.Өлзийсайхан, МУБИС***Abstract**

The overall purpose of the research was to define the tendency of study on educational administrators. The research was analyzed research article, master work and doctoral thesis since 2002. The analyze was carried out on the research year, research content and educational levels. According to the results of research works, articles were raised when policy had been developed on educational reform. Also, the number of master works had been increased. The most content was related to the teacher, obligation of administrators and professional development. Even though, there were the studies on the institutions which were studied their structures and managements. Surprisingly, master work topics were much broader topics comparing to doctoral theses. However, there were limited topics on the education economics, budget, history and legislation. The most issue of research is discussed the general education

**Түлхүүр үг**

Боловсролын удирдлага, чиг хандлага, агуулга

**Удиртгал**

Аливаа шинжлэх ухааны чиглэлээр хийгдэж буй судалгааны чиг хандлагыг судлах нь тухайн шинжлэх ухааны хөгжил, нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлогийг мэдэх боломжтой төдийгүй энэ чиглэлээр ямар зүйлсийг хийж ирсэн, цаашид ямар зүйлс хийх шаардлагатайг урьдчилан таамаглах боломжийг олгодог. Ялангуяа нийгмийн ухааны чиглэлүүдэд энэ нь илүүтэй чухал байдаг. Боловсролын удирдлагын ухааны судалгааны чиг хандлагыг судлах нь боловсролын парадигм, онолын үндэслэлийг ойлгож, нийгмийн хэрэгцээг мэдэрч, бодлого боловсруулагчдад шинээр бодлого боловсруулахад шаардлагатай санаануудыг гаргаж өгч байдаг.

Манай улсад Удирдлагын академи анх мэргэшүүлэх хөтөлбөрөөр боловсролын удирдлагаар мэргэжилтэн бэлтгэж эхэлснээс хойш 20 орчим жил өнгөрчээ. Өнөөдөр хэд хэдэн их, дээд сургуульд сургалтын дараах хөтөлбөрөөр боловсролын удирдлагын мэргэжилтэн бэлтгэж байна. Боловсролын удирдлагын чиглэлийн судлаачид, магистр, докторын зэрэг хамгаалагчид нь боловсролын нийгэм, сэтгэл зүйн үзэгдлүүдийг удирдлагын ухааны үүднээс системтэйгээр судалж, тодорхой үр дүнг гаргасаар ирсэн байна. Боловсролын удирдлагын ухаан нь боловсрол, ялангуяа сургуульд тулгамдаж буй асуудлыг тайлбарлах ухаан тул бодлого, түүний хэрэгжилт, тулгамдаж буй асуудал нь судалгааны ажлын гол сэдвүүд байх нь тодорхой юм. Дээрх хугацаанд манай улсын боловсролын бодлого хэд хэдэн удаа өөрчлөгдөж, дэлхийн жишигт нийцэх

боловсролын тогтолцоо бүрдүүлж, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлүүдийг хийж, хэрэгжүүлж ирсэн. Гэсэн ч эдгээр шинэчлэлүүдийн ололт амжилт, үр ашгийг судалсан судалгаа хангалтгүй түвшинд хийгдэж байна. Энэ нь бид судалгааны чиг хандлага, тэдгээрийн үр дүнг эргэн харж цаашдын чиглэлээ тодорхойлох шаардлагатайг харуулж байна. Тиймээс энэхүү судалгаа өнгөрсөн 20 орчим жилийн хугацаанд хийгдсэн боловсролын удирдлагын чиглэлийн судалгааны ажлуудад анализ хийж энэ салбарын судалгааны чиг хандлагыг тодорхойлохыг зорилоо.

**Судалгааны арга зүй**

Судалгааны чиг хандлагад анализ хийх шалгуурыг эрдэмтэд олон янзаар гаргасан байдаг. Морпи, Вриесенга, & Сторэй (2007)<sup>4</sup> нар судалгааны зорилго, судалгааны арга зүй, судалгааны сэдэв, ишлэл авсан тоо, харин Овенс (2009)<sup>5</sup> судалгааны арга зүй, ишлэл авсан тоо, судлаачдын хүн ам зүйн онцлогуудыг санал болгосон байдаг. Судалгааны зорилгыг судлах нь өмнөх судалгаанууд ямар зорилготой байсан, онол ба бодит байдлыг хэр тэнцвэртэй авч явж байгааг харахад чухал байдаг. Харин судалгааны сэдвийг судлах нь тухайн салбар ухааны судалгааны хамрах хүрээг бүрдүүлэхэд оршиж байдаг. Энэхүү судалгаанд зөвхөн судалгааны ажлын сэдвээр дамжуулан боловсролын удирдлагын ухааны судалгааны чиг хандлагыг судлахыг зорилоо.

Морпи нар (2007) 1979-2003 оны хооронд

<sup>4</sup> Murphy, Vriesenga, & Storey

<sup>5</sup>Owens

\* ulziisaikhan@msue.edu.mn

хийгдсэн Америкийн боловсролын удирдлагын судалгааны ажлуудын чиг хандлагыг судлахдаа судалгааны сэдвийг үндсэн үйл ажиллагаа (core technology: сургуулийг удирдахад шаардагдах чадвар- сургалтын хөтөлбөр, зөвлөн туслах, сургуулийн амжилт, багшлахуй-суралцахуй, үйл ажиллагааны зохицуулалт, хяналт), эдийн засаг төсөв санхүү, жендер ба үндэстэн, хууль эрх зүй, байгууллага, хувь хүн, философи ба ёс зүй, улс төр, сургуулийн удирдлага, сэтгэл судлал, сургуулийн шинэчлэл, удирдах ажилтны ажил үүрэг, бусад гэж ангилан судалсан байдаг. Аливаа чиглэлийн судалгааны ажлын сэдвийг хэрхэн ангилан нь онол, судалгааны шалгуураас гадна нийгмийн хэрэгцээ, сонирхлоос шууд хамаарч байдаг. Энэхүү судалгаанд сэдвийг бодлого төлөвлөлт, хүний нөөц, байгууллага буюу сургууль, сургалт гэж 4 ангилан судаллаа. Энэ 4 ангиллыг дараах байдлаар нарийвчлан задаллаа. Үүнд бодлого, тогтолцоо (боловсролын зорилтуудыг хэрэгжүүлэх механизм), хууль (боловсролын зорилтыг хэрэгжүүлэх хууль, дүрэм, журам), түүх, эдийн засаг санхүү, хүний нөөцийг багшийн хөгжил ба ур чадвар, удирдах ажилтны хөгжил ба ур чадвар, ажил үүрэг, ёс зүй, хүний нөөц, байгууллагыг менежмент, хөгжил, сургалтыг сургалтын орчин, багшлахуй (хичээлтэй шууд холбоотой) гэж ангиллаа. Гэвч судалгааны явцад ялангуяа зарим магистрын ажлын сэдвүүд дээрх ангилалд үл хамаарах тохиолдол гарч байсан тул олон нийт гэсэн ангиллыг нэмж оруулан, үүнийг дотор нь оролцоо, сурагчийн онцлог, багш сурагчийн харилцаа гэж ангиллаа.

Судалгааны чиг хандлагыг агуулгаар ангилахаас гадна боловсролын шатлалаар нь ангилж судаллаа. Боловсролын шатлалын тухайд манай улсын Боловсролын тухай хуульд заасны дагуу сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсрол, насан туршийн боловсрол гэж ангилж үзлээ. Үүний эхний 4 нь албан боловсролын тогтолцоонд, сүүлийнх нь албан бус боловсролын тогтолцоонд хамаарах юм. Эдгээр шатлалын хэд хэдийг эсвэл бүгдийг хамарч буй тохиолдолд нийтлэг гэж ангилсан болно.

### Судалгааны өгөгдөл

Дээрх зорилгын хүрээнд энэхүү судалгаа боловсролын удирдлагын чиглэлээр хийгдсэн судалгааны чиг хандлагад эрдэм шинжилгээний өгүүлэл, докторын диссертаци, магистрын ажил гэсэн 3 чиглэлээр анализ хийсэн. Эрдэм шинжилгээний өгүүллийн чиг хандлагыг судлахдаа Боловсрол судлал сэтгүүл

(Боловсролын шинжлэх ухааны академи), Лавай (Монгол улсын Боловсролын их сургууль, МУБИС) сэтгүүлийг сонгон авсан. Харин докторын диссертаци, магистрын ажлыг судлахдаа МУБИС-ийн боловсролын удирдлагын мэргэжлээр төгсөгчдийн ажлыг сонгон авлаа. Судалгаанд ашигласан өгөгдлийн цаг хугацааны хамрах хүрээг эрдэм шинжилгээний өгүүллийн хувьд тухайн сэтгүүл хэвлэгдэж эхэлсэн он буюу 2001, 2006 онуудаас хойш, төгсөгчдийн ажлын хувьд 2002 оноос хойш өнөөг хүртэл сонгон авч судаллаа. Магистр, докторын зэрэг хамгаалсан боловсролын удирдлагын бүтээлүүдийг дараах байдлаар цуглууллаа. Магистрын бүтээлийг МУБИС-ийн Боловсролын удирдлагын тэнхимийн бүртгэл, номын сангийн цахим хайлтаар цуглуулсан. Харин докторын диссертацийг Боловсрол судлалын докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүртгэл, Шинжлэх ухаан, технологийн сангийн цахим хайлтыг ашиглан цуглууллаа. Үүний дүнд 148 эрдэм шинжилгээний өгүүлэл, 59 докторын диссертаци, 990 магистрын ажил цуглуулан анализ хийлээ.

### Судалгааны үр дүн

Эрдэм шинжилгээний сэтгүүлд боловсролын удирдлагын чиглэлээр хэвлэгдсэн өгүүллүүдэд хийсэн анализын үр дүнг Хүснэгт 1, 2-т харуулав. Боловсрол судлал, Лавай сэтгүүлд дээрх ангилалд багтаж буй өгүүллийг сонгон авч үзэхэд нийт 148 өгүүлэл байна. Он тархалтыг харвал 2006, 2008, 2012, 2013, 2016 онуудад хамгийн олон буюу нийт өгүүллийн 53 хувь нь хамрагдаж байна. 2011 онд хамгийн бага буюу 1 өгүүлэл байна.

#### Хүснэгт 1

Өгүүллийн хэвлэгдсэн он ба тоо



Он	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010
Өгүүллийн тоо	4	9	8	9	20	10	18	4	5
Он	2011	2012	2013	2014	2015	2016	2017	Бүгд	
Өгүүллийн тоо	1	15	14	7	4	12	8	148	

Судалгааны өгүүллийн хамрах хүрээ, агуулгыг судалж үзэхэд 6% (9 өгүүлэл) нь СӨБ, 55% (82) нь ерөнхий боловсрол, 4.7% (7) нь мэргэжлийн боловсрол, 13.4% (20) нь дээд боловсрол, 20.8% (31) нь нийтлэг чиглэлээр бичигдсэн байна. Эдгээрийг агуулгаар авч үзвэл бодлого төлөвлөлтийн чиглэлээр 41.6% (62), хүний нөөцийн чиглэлээр 44.3% (66),

байгууллагын чиглэлээр 14.1% (21) нь бичигджээ. Агуулгын тархалтыг Хүснэгт 2-т дэлгэрэнгүй харуулав.

### Зураг 1

Эрдэм шинжилгээний өгүүллийн агуулгын тархалт (агуулга, боловсролын шатлал)



Бодлого, түүхийн чиглэлийн өгүүлэл нь тодорхой нэг боловсролын шатаар хязгаарлалгүй бүх шатлалыг хамарсан байна. Эрх зүйн чиглэлийн өгүүлэл бүх түвшинд адил тархалттай байна. ЕБ-ын түвшинд хийгдсэн эрх

зүйн чиглэлийн судалгаа нь сургуулийн орчинд мөрдөгдөх дүрэм журам, түүний хэрэгжилтэд анализ хийсэн бол дээд боловсролын хувьд магадлан итгэмжлэл, дотоод хяналтын агуулгууд гол сэдэв байна.

Төсөв санхүүгийн чиглэлийн хувьд мэргэжлийн боловсролын түвшинд бичигдээгүй байна. Харин хүний хөгжлийн өгүүлэл нь ерөнхий боловсролын салбарт хамгийн их бичигдсэн байна. Үүнд: Удирдах ажилтан бэлтгэх, багш, удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийн асуудал багтсан. Бусад салбарын хувьд ч мэргэжлийн хөгжлийн асуудал чухал агуулгыг эзэлж байна. Ажил үүргийг судалсан өгүүлүүдийн 80% нь ЕБС-ийн багшийн ажилтай хамаарч байна. Үүнд: багш удирдах ажилтны үүрэг, ажлын ачаалал хамгийн их хөндөгдсөн байна. Ялангуяа 2006 онд хэвлэгдсэн 10 өгүүлэл нь ЕБС-ийн багшийн ажлын ачааллыг судалсан байна. 2013 онд хэвлэгдсэн 7 судалгаа нь сургуулийн захирал, сургалтын менежерийн ажлын чиг үүрэг, түүний хэрэгжилтийг хүний нөөцийн бодлого, стандарт хэрэгжилтийн талаас нь судалсан байна. Байгууллагын бүтэцтэй холбоотой судалгаа 2012 оноос хэвлэгджээ. Үүнд сургуулийн зураглал (судалгааны гарчигт зураглал гэдэг үгийг ашигласан)-тай холбоотой өгүүлэл дийлэнх хувийг эзэлж байна.

Сургалтын орчны агуулгатай холбоотой судалгаанууд ерөнхий боловсролын түвшний сургалтын орчны стандарт, сурах бичгийн талаар судалсан байна.

### Хүснэгт 2

Эрдэм шинжилгээний өгүүллийн агуулгын чиглэл

	Ангилал		Боловсролын түвшин					Бүгд
			СӨБ	ЕБ	МБ	ДБ	Нийтлэг	
Бодлого, төлөвлөлт	Бодлого, тогтолцоо	Тоо	2	11	2	4	14	33
		%	6.1%	33.3%	6.1%	12.2%	42.4%	100%
	Түүх	Тоо	0	0	0	0	5	5
		%	0.0%	0.0%	0.0%	0.0%	100%	100%
	Эрх зүй	Тоо	2	6	3	3	5	19
		%	10.5%	31.6%	15.8%	15.8%	26.3%	100%
Санхүү	Тоо	1	1	0	2	1	5	
	%	20.0%	20.0%	0.0%	40.0%	20.0%	100%	
Хүний нөөц	Хүний хөгжил	Тоо	0	14	1	5	4	24
		%	0.0%	58.3%	4.2%	20.8%	16.6%	100%
	Ажил, үүрэг	Тоо	3	33	1	2	2	41
		%	7.3%	80.2%	2.4%	4.9%	4.9%	100%
Байгууллага	Бүтэц	Тоо	0	10	0	1	0	11
		%	0.0%	90.9%	0.0%	9.1%	0.0%	100%
	Хөгжил	Тоо	0	1	0	1	1	3
		%	0.0%	33.3%	0.0%	33.3%	33.3%	100%
	Орчин	Тоо	1	6	0	0	0	7
		%	14.3%	85.7%	0.0%	0.0%	0.0%	100%
Бүгд	Тоо	9	82	7	18	32	148	
%	6.1%	55.0%	4.7%	12.2%	21.6%	100%		

МУБИС-ийн төгсөгчдийн бүртгэл, Шинжлэх ухаан, технологийн сангийн цахим хуудсыг ашиглан 1987 оноос 2017 онуудад хамаарах 59 докторын бүтээл цуглууллаа.

## Хүснэгт 3

## Докторын диссертацийн он

Он	1987	1996	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	
Диссертацийн тоо	1	1	2	1	2	1	6	6	3	4	
Он	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	Бүгд
Диссертацийн тоо	4	1	2	2	3	3	2	6	7	1	58
* Нэг бүтээлийн он тодорхойгүй тул оны тархалтад оруулаагүй.											

Докторын диссертацийн хөндсөн асуудлууд боловсролын аль шатанд хамаарахыг судалж үзэхэд СӨБ-ын асуудлыг дангаар хөндсөн судалгаа байхгүй байна. Харин ерөнхий боловсролын чиглэлийн 18 (30.5%) ажил, мэргэжлийн боловсролын чиглэлийн 3 (5.1%) ажил, дээд боловсролын чиглэлийн 25 (42.4%) ажил, боловсролын салбарын нийтлэг асуудлыг хамарсан 11 (18.6%) ажил, насан туршийн боловсролын чиглэлийн 2 (3.4%) ажил байна.

Агуулгыг багцлан авч үзэхэд бодлого төлөвлөлтийн чиглэлээр 22 (37.8%), хүний нөөцийн чиглэлээр 24 (48.6%), сургалтын чиглэлээр 24 (40.7%), байгууллагын чиглэлээр 13 (22.0%) ажил тус тус байна.

Хүний нөөцийн чиглэлээр бичигдсэн агуулгын дийлэнх нь дээд боловсролын хүрээнд мэргэжилтэн бэлтгэх, ерөнхий боловсролын шатанд багшийн хөгжлийн тухай асуудал байна. Байгууллагын тухай агуулгад байгууллагын хяналт шинжилгээ, удирдлагын менежментийн асуудал түлхүү байна.

## Хүснэгт 4

## Докторын диссертацийн агуулгын чиглэл

Ангилал			Боловсролын түвшин					Бүгд
			ЕБ	МБ	ДБ	нийтлэг	НТБ	
Бодлого төлөвлөлт	Бодлого, тогтолцоо	Тоо	4	2	1	4	2	13
		%	30.7%	15.4%	7.7%	30.7%	15.4%	100%
	Түүх	Тоо	0	0	0	2	0	2
		%	0%	0%	0%	100%	0%	100%
	Эрх зүй	Тоо	1	1	1	2	0	5
		%	20.0%	20.0%	20.0%	40.0%	0%	100%
Төсөв санхүү	Тоо	0	0	0	2	0	2	
	%	0%	0%	0%	100%	0%	100%	
Хүний нөөц	Хүний хөгжил	Тоо	7	0	3	0	0	10
		%	70.0%	0%	30.0%	0%	0%	100%
	Ажил, үүрэг	Тоо	4	0	0	0	0	4
		%	100%	0%	0%	0%	0%	100%
	Мэргэжилтэн бэлтгэх	Тоо	0	0	10	0	0	10
		%	0%	0%	100%	0%	0%	100%
Байгууллага	Менежмент, хөгжил	Тоо	2	0	10	1	0	13
		%	15.4%	0%	76.9%	7.7%	0%	100%
Бүгд		Тоо	18	3	25	11	2	59
%			30.5%	5.1%	42.4%	18.6%	3.4%	100%

Боловсролын удирдлагын чиглэлээр бичсэн магистрын ажилд анализ хийхдээ боловсролын удирдлагын тэнхим байгуулагдаж анхны төгсөлтөө хийсэн 2003 оноос өнөөг хүртэлх хугацааг сонгож авсан. Оны тархалтаар харвал сүүлийн жилүүдэд төгсөгчдийн тоо нэмэгдэх хандлагатай байна.

### Хүснэгт 5

Магистрын ажил /оны тархалтаар/


Он	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010
Магистрын ажил	22	12	31	29	19	12	47	24
Он	2011	2012	2013	2014	2015	2016	2017	Бүгд
Магистрын ажил	52	168	128	62	178	112	94	990
* зарим онуудын хувьд энэ хүснэгтэд байгаа тоо нь төгсөгчдийн статистик тоотой тохирохгүй. Өөрөөр хэлбэл зөвхөн магистрын ажлын сэдвүүд нь мэдэгдэж байгаа тоог авсан болно.								

Магистрын ажлын хөндсөн асуудлыг боловсролын түвшнээр судалж үзэхэд СӨБ-ын чиглэлийн 190 (нийт магистрын ажилд эзлэх хувь 19.2%), ерөнхий боловсролын чиглэлийн 673 (67.9%), мэргэжлийн боловсролын чиглэлийн 24 (2.4%), дээд боловсролын чиглэлийн 43 (4.3%), боловсролын салбарын нийтлэг асуудлыг хамарсан 36 (3.6%), насан туршийн боловсролын чиглэлийн 24 (2.4%) ажил тус тус байна.

Агуулгыг багцлан авч үзэхэд бодлого төлөвлөлтийн чиглэлээр 57 (5.8%), хүний нөөцийн чиглэлээр 481 (48.6%), сургалтын чиглэлээр 230 (23.3%), байгууллагын чиглэлээр 79 (7.9%), олон нийттэй холбоотой чиглэлээр 143 (14.4%) ажил тус тус байна.

### Зураг 2

Магистрын ажлын агуулгын тархалт (агуулга, боловсролын шатлал)



Бодлогын чиглэлээр хийгдсэн судалгаануудын дийлэнх нь сургалтын хөтөлбөр, Засгийн газраас гаргасан хөтөлбөрүүдийн хэрэгжилт, тогтолцоонд хамаарах судалгаанууд нь боловсролын системийн хэвийн үйл ажиллагааны талаар тус тус судалжээ. Эрх зүйн чиглэлийн судалгаанууд 2013 оноос боловсролын хуулийн шинэчлэлийн асуудлыг түлхүү, төсөв, санхүүгийн чиглэлийн судалгаа нь 2003-2005,

2013 оноос хойших үед харгалзаж байгаа бөгөөд бүгд санхүүжилтийн механизмыг сайжруулах асуудлыг тус тус хөндсөн байна.

Магистрын ажлын дийлэнхийг багшийн хөгжлийн сэдэвтэй холбоотой ажлууд эзэлж байна. Эдгээр нь хэдийгээр багшийн хөгжлийн асуудлыг хөндөж байгаа боловч судалгааны арга зүй, судалгааны таамаглал, хамрах хүрээ зэргээрээ ялгаатай. Жишээ нь зөвхөн багш

ажлын байрандаа хөгжихтэй холбоотой 45 ажил байгаа хэдий ч зарим СӨБ-ийн багшийн хөгжил, зарим нь ЕБС-ийн багшийн хөгжлийг судалж, үүн дотроо хөгжих боломж орчин эрхзүйн нөхцөл, хөгжих хэрэгцээ, хөгжиж буй байдлыг асуулгын арга, туршилтын арга зэргээр хийснээрээ ялгарч байна. Гэсэн ч энэхүү судалгаа нь магистрын ажлын агуулгын чиглэлийг судлахдаа тухайн ажлын сэдэв (гарчиг)-ийг авч үзсэн тул өмнөх дүгнэлтийг нотлохын тулд нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

Удирдах ажилтны хөгжил, ур чадварын асуудлыг хөндсөн судалгааны дийлэнх нь буюу 43 нь сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтны ажлын арга барилын онцлог, ур чадварын түвшинг дангаар нь эсвэл бусад хувьсагчидтай хамааруулан судалсан байна. Багшийн ажлыг судалсан судалгаанууд нь багшийн үйл ажиллагаа, ажлын ачаалал, ажлын үнэлгээ, ажлын сэтгэл ханамж, мотиваци зэрэг асуудлыг хөндөж судалсан байна.

Боловсролын байгууллагын багш, удирдах ажилтны ёс зүй, харилцааны талаарх судалгаа ЕБС-ийн хүрээнд их судлагдсан байна. Үүнд багш, удирдах ажилтны ёс зүй түвшин, харилцааны чадвар, тулгамдаж буй асуудал зэргийг судалсан байна. Судалгааны ажлын сэдвээс харахад давхардал ихтэй харагдаж буй боловч судалгааны арга, хамрах хүрээ, судалгаанд тооцсон хувьсагч зэргийг нарийвчлан судлах шаардлагатай. Хүний нөөцийн чиглэлээр хийгдсэн судалгаануудын 50% нь сургууль, цэцэрлэгийн хүний нөөцийн бүрдүүлэлтийн асуудлыг хөндсөн байна. Багш бэлтгэх, томилох, хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах зэрэг нь боловсролын удирдлагын ухааны

судлах зүйл мөн боловч магистрын ажлуудын дийлэнх нь сургууль, цэцэрлэг багшаа хэрхэн сонгон шалгаруулж авдаг тухай бичсэн байгаа нь сүүлийн үеийн судалгаанаас харагдаж байна.

Сургалтын агуулгаар бичигдсэн ажлуудын дийлэнхийг танхимд өрнөж буй сургалтын технологийн асуудлыг хөндсөн судалгаанууд эзэлж байна. Үүнд: сургалтын арга зүй турших, сургалтын явцыг үнэлэх, сурагчийн чадварт анхаарсан асуудлууд багтаж байна. Мэргэжлийн боловсролын байгууллагын хувьд цогц чадамжид суурилсан сургалттай агуулга сүүлийн жилүүдэд их байна.

Байгууллагатай холбоотой агуулга нь сургууль, цэцэрлэгийн бүтэц, төлөвлөлт, шийдвэр гаргалт, соёл, үнэлгээ, менежмент зэрэг асуудлыг багтаасан байна.

Олон нийт гэсэн агуулгад оролцоо, сурагчийн онцлог, багш-сурагчийн харилцааг багтаасан. Сурагчийн онцлогийг судалсан ажлууд нь суралцагчийн хувийн онцлог, суралцахуйн онцлог, төлөвшлийн онцлог зэрэг асуудлыг хөндсөн байна. Өөрөөр хэлбэл боловсролын удирдлагад шууд хамаарах сэдэв бус сэтгэл судлал, боловсрол судлалын судалгааны агуулгууд байна. Мөн багш сурагчийн харилцааг хөндсөн ажлууд байгаа боловч доторх агуулгын хувьд шууд боловсролын удирдлагад хамааруулахад хүндрэлтэй юм. Харин оролцоотой холбоотой агуулга нь боловсролын байгууллагад эцэг эхийн оролцоо нь ямар хүрээнд, түвшинд байгааг харуулах, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх ямар ямар боломжууд буйг илрүүлэх, туршиж үр дүнг харуулах зэрэг ажлууд зонхилж байна.

## Хүснэгт 6

### Магистрын ажлын агуулгын чиглэл

Агуулгын чиглэл			Боловсролын шатлал						Бүгд
			СӨБ	ЕБ	МБ	ДБ	Нийтлэг	НТБ	
Бодлого төлөв-лөлт	Бодлого, тогтолцоо	Тоо	6	19	0	2	9	4	40
		%	15.0%	47.5%	0.0%	5.0%	22.5%	10.0%	2.7%
	Эрх зүй	Тоо	0	4	0	3	1	0	8
		%	0.0%	.6%	0.0%	7.0%	2.8%	0.0%	.8%
	Төсөв санхүү	Тоо	1	5	0	0	3	0	9
		%	.5%	.7%	0.0%	0.0%	8.3%	0.0%	.9%
Хүний нөөц	Багшийн хөгжил, чадвар	Тоо	24	128	6	3	0	0	161
		%	12.6%	19.0%	25.0%	7.0%	0.0%	0.0%	16.3%
	Удирдах ажилтны хөгжил, чадвар	Тоо	20	40	0	0	1	0	61
		%	10.5%	5.9%	0.0%	0.0%	2.8%	0.0%	6.2%
	Багшийн ажил	Тоо	33	116	2	3	1	1	156
		%	17.4%	17.2%	8.3%	7.0%	2.8%	4.2%	15.8%
	Багш, удирдах ажилтны ёс зүй	Тоо	10	47	1	1	0	0	59
		%	5.3%	7.0%	4.2%	2.3%	0.0%	0.0%	6.0%
	Хүний нөөц менежмент	Тоо	6	26	1	3	7	1	44
		%	3.2%	3.9%	4.2%	7.0%	19.4%	4.2%	4.4%

Сургалт	Орчин, хэрэглэгдэхүүн	Тоо	5	18	0	4	0	1	28
		%	2.6%	2.7%	0.0%	9.3%	0.0%	4.2%	2.8%
	Сургалтын технологи	Тоо	19	142	10	15	4	12	202
		%	10.0%	21.1%	41.7%	34.9%	11.1%	50.0%	20.4%
Байгуул-лага	Менежмент	Тоо	13	30	2	4	6	1	56
		%	6.8%	4.5%	8.3%	9.3%	16.7%	4.2%	5.7%
	Хөгжил	Тоо	10	13	0	0	0	0	23
		%	5.3%	1.9%	0.0%	0.0%	0.0%	0.0%	2.3%
Олон нийт	Оролцоо	Тоо	21	33	1	2	4	2	63
		%	11.1%	4.9%	4.2%	4.7%	11.1%	8.3%	6.4%
	Сурагчийн онцлог	Тоо	19	24	1	2	0	1	47
		%	10.0%	3.6%	4.2%	4.7%	0.0%	4.2%	4.7%
Багш-сурагчийн харилцаа	Тоо	3	28	0	1	0	1	33	
	%	1.6%	4.2%	0.0%	2.3%	0.0%	4.2%	3.3%	
Бүгд		Тоо	190	673	24	43	36	24	990
%		100%	100%	100%	100%	100%	100%	100%	

## Дүгнэлт

Энэ судалгаагаар боловсролын удирдлагын судалгааны чиг хандлагыг шинжлэх ухааны өгүүлэл, докторын диссертаци, МУБИС-ийн магистрын ажлуудын сэдвийн хүрээнд судаллаа. Судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Хийгдсэн судалгааг тооны хувьд авч үзэхэд шинжлэх ухааны өгүүллийн тоо нь боловсролын шинэчлэлийн бодлогууд хэрэгжиж эхэлсэн онуудад өндөр давтамжтай гарсан байна. Үүнийг боловсролын шинэчлэл хийхтэй холбоотойгоор эрдэм шинжилгээний байгууллага болон судлаачид холбогдох асуудлаар олон судалгаа хийснээр тайлбарлаж болох юм. Учир нь 2006-2008, 2012, 2013 онуудад харгалзах өгүүллүүд 2006 оны Боловсролын салбарын мастер төлөвлөгөө, 2012-2013 онд Боловсролын шинэчлэлийн бодлогын зорилго, агуулгатай төстэй байна. Харин Магистрын ажлын тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж гарсан нь энэ мэргэжлийн нийгмийн хэрэгцээ их, мэргэжлээр суралцах сонирхол их байгааг харуулж байна.

Судалгааны агуулгын хамрах хүрээг авч үзвэл багш, удирдах ажилтны ажил үүрэг, мэргэжлийн хөгжилтэй холбоотой сэдвүүд дийлэнх байна. Энэ нь боловсролын шинэчлэлийн бодлогод багшийн хөгжил, ажил үүргийн өөрчлөлтийн асуудал чухлаар хөндөгдөж байсантай холбоотой. Байгууллагын талаар судалсан судалгаанууд бүтэц, менежментийн чиглэлээр хийгдсэн байна. Харин магистрын ажлууд шинжлэх ухааны өгүүлэл, докторын диссертацитай харьцуулахад илүү өргөн хүрээг хамарсан байна. Сургалтын технологи, багш, сурагчийн онцлогтой холбоотой сэдвүүд олон байгаа нь тухайн мэргэжлээр суралцагчдын дийлэнх нь сургууль, цэцэрлэгийн багш байдагтай холбож тайлбарлаж болно. Мөн багш удирдах, ажилтын ёс зүйтэй холбоотой сэдвүүд олон байгаа

нь сургуулийн орчинд энэ нь тулгамдсан асуудал болж, үүнийгээ ямар нэг аргаар шийдвэрлэхээр магистрын судалгааны ажил авч байгааг харуулж байна.

Боловсролын удирдлагын чиглэлийн судалгаанууд өнгөрсөн хугацаанд агуулгын хувьд өргөн хүрээг хамарч байгаа ч боловсролын эдийн засаг, төсөв санхүү, түүх, хууль эрх зүйн чиглэлийн судалгаа бага хийгдсэн нь цаашид энэ чиглэлийн судалгаа хангалтгүй байна. Судалгаагаар хөндсөн асуудлын дийлэнх нь ерөнхий боловсролын түвшинд харгалзаж байгаа нь сургуулийн өмнөх боловсрол, мэргэжлийн боловсролын түвшинд судалгаа хийх шаардлагатайг харуулж байна. Мөн дийлэнх судалгаанууд нөхцөл байдлыг тодорхойлох чиглэлээр хийгдэж байгаа нь өнөөгийн байдлыг ойлгоход чухал боловч бодлого, тогтолцооны үр ашгийг тооцсон судалгаанууд үгүйлэгдэж байна.

## Ашигласан материал

- Murphy, J., Vriesenga, M., & Storey, V. (2007). Educational Administration Quarterly, 1979-2003: An analysis of types of work, methods of investigation and influences. *Educational Administration Quarterly*, 43(5), 612-628.
- Owens, M. A. (2009). The William J. Davis Award. An Analysis of Trends: From 1980 to 2007. *Educational Administration Quarterly*, 45(3), 474-494.
- Боловсролын судлал сэтгүүл. From: [www.bolovsrolsudlal.mn](http://www.bolovsrolsudlal.mn).
- Шинжлэх ухаан технологийн сан. From: <http://www.stf.mn/infodb/list/1>
- МУБИС-ийн Номын сан: From: <http://mnue.mn/home/detail/2684a879-aba0-4f6b-ae6c-abdc7eaa7ee8>